БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 06 өдөр Дугаар А/36 Улаанбаатар хот

Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, цагаан сарыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.4, 12.5, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 07/01 дүгээр тогтоолын 2.2-2 дахь заалт, дүүргийн Засаг даргын 2018 оны Б/02 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, цагаан сарыг тохиолдуулан дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд хороодын өндөр настай, харьяалалгүй, зорилтот өрхийн ахмадуудыг хамруулахад анхааран, үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн тайланг 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс /А.Одонтунгалагтуул/-т болон хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.НАРАНГЭРЭЛ

1160200086